

Боржигин чуулгын даргын 2019 оныг  
09 сарын 12 ны өдрийн  
1/55 тоот тушаалын 3...-р хавсралт

УБЖ0004 9018664

## ТОГЛОЛТЫН ХУВЦАС ТҮРЭЭСЛЭХ ЖУРАМ

### Нэг. Зорилго

Мэргэжлийн урлагийн байгууллага нь өөрийн орлогыг бүрдүүлэх, Аж ахуйн нэгж, албан байгууллага, иргэдэд соёл урлагийн үйл ажиллагаа, арга хэмжээнд нь дэмжлэг үзүүлэхэд оршино.

### Хоёр. Ерөнхий зүйл

Чуулгын хувцасны фондонд байгаа концерт, жүжиг, уран бүтээлүүдийн /сүүлийн 4 жилээс өмнөх/ хувцасыг зохих зөвшөөрлийн дагуу байгууллага, хувь хүмүүст түрээслэхэд доорхи үнэ тарифыг баримтлана. Чуулгын хувцасны фондоод байгаа нийт хувцасыг **А, В** гэсэн зэрэглэлээр ангилна.

**А.** зэрэглэлд – Тайзнаа гарч буй шинэ уран бүтээлүүдийн хувцас хамаарна.

**В.** зэрэглэлд - Сүүлийн 4 жилээс өмнөх хийгдсэн хувцас хамаарна.

**А** Зэрэглэлийн хувцасыг гадагш түрээслэхгүй болно.

**В** Зэрэглэлийн хувцасыг 24 цагийн хугацаатай тогтоосон үнэ тарифын дагуу түрээслэнэ.

### Гурав. Түрээслэгчийн үүрэг

3.1 Түрээслэгч нь хувцасны тоо ширхэг, хугацаа заасан хүсэлт /тусгай хүснэгт бүхий хуудас/-ыг гарган чуулгын хувцасны эрхлэгчээр дамжуулан байгууллагын даргын зөвшөөрөл авна.

3.2 Түрээслэгч зөвшөөрөгдсөн тохиолдолд үнийн дүнг 100% бэлнээр буюу байгууллагын дансанд байршуулсанаар хувцасыг авна.

3.3 Түрээслэгч нь хугацааг хатуу баримтлан, түрээслэсэн хувцасаа үрэгдүүлэх, бохирдуулах зэрэг гэмтэл учруулсан тохиолдолд анх хийгдсэн үнийн дүнгээр төлнө.

### Дөрөв. Түрээслүүлэгчийн үүрэг

4.1 Түрээслэгч талын хүсэлтийн дагуу зохих зөвшөөрөлийг олгоно.

4.2 Түрээсээр өгөх зүйлийн бүрэн бүтэн байдлын талаар тусгай тэмдэглэл хөтлөн гарын үсгээр баталгаажуулж олгоно.

4.3 Түрээсийн төлбөрийг бүрэн хэмжээгээр авах, бохирдуулах, алдагдсан тохиолдолд захиргаанд мэдэгдэн төлбөрийг түрээслэгч талаас гаргуулах

## ХУВЦАС ТҮРЭЭСЛЭХ ҮНЭ ТАРИФ

№	Ангилал	Тоо ширхэг	Үнэ
1	Тоглолтын дээл	1	15000
2	Тоглолтын дээл, бүс, малгай	1	20000
3	Тоглолтын гутал	1	10000
4	Тоглолтын дээл бүс, малгай, гутал	1	30000
5	Плать	1	20000
6	Костюм	1	20000
7	Хантааз	1	10000